



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
БАЯНЖАРГАЛАН СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

2023 оны 07 сарын 06 өдөр

Дугаар 16

Аргатай

Сумын амьжиргааг дэмжих зөвлөлийг  
шинэчлэн батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1, Нийгмийн халамжийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2, 27.3 дахь заалт, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2012 оны А/89 дүгээр тушаалаар батлагдсан “Амьжиргааг дэмжих зөвлөлийн дүрэм”-ийн 2 дугаар зүйл зэргийг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын арван зургаадугаар хуралдаанаас ТОГТООХ нь :

1. Сумын амьжиргааг дэмжих орон тооны бус зөвлөлийг доорхи бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулсугай.

Зөвлөлийн нарийн бичгийн дарга Ц.Эрдэнэчимэг ХХҮ хариуцсан мэргэжилтэн  
а.Төрийн байгууллагын төлөөлөл

Д.Мөнхзул Нийгмийн даатгалын байцаагч  
С.Үржинханд ЭМТ-ийн эх баригч эмч

б.Төрийн бус байгууллагын төлөөлөл:

Ж.Рэгзэдмаа Ахмадын хорооны дарга  
Н.Мөнхчимэг Түвшин Энгүүмэл ХХК-ны төлөөлөл

в.Иргэний төлөөлөл Г.Бадамханд Аргатай 3-р багийн иргэн  
Г.Цэцгээ Аргатай 3-р багийн иргэн

2. Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2012 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн А/89 тоот тушаалаар батлагдсан амьжиргааг дэмжих зөвлөлийн дүрмийг мөрдөж ажиллахыг Амьжиргааг дэмжих зөвлөлийн гишүүдэд үүрэг болгосугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 06 дугаар сарын 29-ны өдрийн 17 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА  Д.ЭРДЭНЭБАТ

